

УДК 24

## ТОД ҮСГЭЭР ҮЙЛДСЭН БУДДЫН ШАШНЫ АЛТАН ГЭРЭЛ СУДРЫН ХЭЛНИЙ ШИНЖИЛГЭЭ

Даваадорж Бавалын

Ph.D, дэд профессор.

Ховд их сургууль, Ховд, Монгол Улс

E-mail: davaadorj\_bb@yahoo.com

### Товч хураангуй

«Алтан гэрэл судар» бол Их хөлгөний бурхан шашины хамгийн хүндтэй сударуудын нэг юм. «Алтан гэрлийн судар»-ыг төвд эхээс ойрад хэлээр Зая бандид орчуулга хийсэн. XVII зууны дунд үеэс уг зохиол ойрад хэлэнд орчуулагдсанаас хойшхи зуун жилийн хугацаанд судар зөвхөн гар бичмэл хэлбэрээр байсан. XVIII зууны дунд үеэс Зүүнгарын хаант улсад ксилографийн аргаар, дараа нь Халимагийн хаант улсад Ижил мөрний халимагуудын санаачилгаар Дондук-Дашигийн үед (1741–1761) хэвлэгджээ. Энэ халимаг ксилографын хуулбар Ш. Үвэлзэн гэнгэгийн хувийн цуглуулгад хадгалагдаж байгаа (Тэкэс, Шинжаан, Хятад). “Алтан гэрэл судар”-ын ойрад орчуулга Оросын судлаачдын хараанаас холдсонгүй. Алтангэрэл их хөлгөн судрын бичвэрт ойрад аялгууны содон сонин үгсийг хэрэглэсэн эсэх, монгол бичгийн хэлний зөв бичихүйтэй яаж уялдаж уламжлагдсан, үгийг хувилган зөв бичихүйг ямар байдлаар баримталж бичиж байсан зэргийг 1655 оны үеийн орчуулгын баримтаар тодруулан тайлбарласан болно. Тод үсгийн бичвэрт монгол бичгийн адилаар үгийн төгсгөлийг анхаарч, үгийн үндэс нь задгай үеэр төгссөн, битүү үеэр төгссөн эсэхийг харгалзан дагаврыг залгахад, залгаж буй дагавар нь эгшгээр эхэлсэн, гийгүүлэгчээр эхэлсэн хоёр хувилбартай бөгөөд эр үг, эм үгэнд нэг л дүрсээр бичиж байна. Ийнхүү тод үсэг, монгол бичгийн дагаврын тэмдэглэгээ нь адил гэж болох боловч чанарын ялгаатай бололтой.

### Түлхүүр үг

Алтангэрэл, ойрад орчуулга, бурхан шашин, тийн ялгал, тоо, нөхцөл, дэвсгэр үсэг, задгай үе, бичвэр, авиа.

UDC 24

## **BUDDHIST SUTRA OF GOLDEN LIGHT IN CLEAR WRITING: LANGUAGE ANALYSIS**

---

**Davaadorj Bavaly**

Ph.D, Associate Professor.

Khovd University, Khovd, Mongolia

E-mail: davaadorj\_bb@yahoo.com

### **Brief summary**

---

The Golden Light Sutra is one of the most revered scriptures in Mahayana Buddhism. The Golden Light Sutra was translated from the Tibetan language into the Oirat language by Zaya pandit. From the middle of the seventeenth century onwards, for a hundred years after the text was translated into Oirat, the scriptures were only in manuscript form. It was published in the middle of the 18th century by xylography in the Dzungarian Empire, and later in the Kingdom of Kalmykia by the Volga Kalmyks during the Donduk-Dashi period (1741–1761). A copy of this Kalmyk xylograph is kept in a private collection of Sh. Uvelzen (Tekes, Xinjiang, China). The recent translation of the “Golden Light Sutra” has not escaped the notice of Russian scholars. A 1655 translation document explains whether Altangerel used strange dialectal words in the text of the Mahayana sutras, how they were related to the correct spelling of the Mongolian written language, and how he copied the words correctly. In bold script, like the Mongolian script, pay attention to the end of the word, depending on whether the root of the word ends in open or closed, the suffix has two variants, beginning with a vowel and beginning with a consonant. Thus, the bold letters and the suffixes of the Mongolian script can be said to be the same, but the quality seems to be different.

### **Keywords**

---

Altan gerel, Oirat translation, Buddhism, case, number, condition, background letter, open syllable, text, sound.

## О Р Ш И Л

Монгол оронд бурханы шашин дэлгэрэхэд Алтангэрэл судар дэлгэрсэн. Ер нь тухайн улс оронд бурханы шашин дэлгэрэхэд ямар нэг судраар дамжиж дэлгэрсэн байдаг. Үүний нотолгоо нь монгол нэртэй Алтангэрэл судар (Altan Gerel, 1929; Yakhontova, 2006; Батсуурь, 2008; Бичеев, 2015 и др.).

Төвөд хэлнээс хөрвүүлж, тод үсгээр бичсэн “Хутагт судрын аймгийн эрхэт хаан дээд Алтангэрэл хэмээх их хөлгөний судар оршвой” хөлгөн судрын бичвэрт нэр үгийн хувиллыг хэрхэн тэмдэглэснийг тодруулан үзье.

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### Нэрийн тийн ялгал

#### Нэрлэхийн тийн ялгал

Нэрлэхийн тийн ялгалын утгаар үйлийн эзнийг тэмдэглэхдээ тухайн үг нь – n- тэй байваас тэр хэлбэрээр бичсэн

Gegeān **nasun** oqor bolqu. Yamaāru **naran** metü badaran. Ācegeiyin **quran** ċu oroboy.

Нэр үгийг олны утга заасан дагавар, зарим үгээр тодотгосон

Āceq-noyoūd urγun. Tende qamuq **yertünčü-ner** üjeküleā. **Amitan bügüde** mayad meden üyiledkü. **Düley-noyoūd** sedkildü taālaquy **doün-noyoūdi** sonosqu boltuγay. **Doün ċu** γarbay. Ācegeiyin **quran ċu** oroboy.

Үйлийн эзэн гэсэн утгаар төлөөний үгийг нэрлэхийн тийн ялгалын хэлбэрээр нь бичсэн

**Tere** basa sedkibey. **Bi** ċima-du ögüye.

хэмээн үйлийн эзнийг дурдсан байдлаар хэлбэржүүлсэн нь түгээмэл байна.

### Харьяалахын тийн ялгал

Их хөлгөн судрын бичвэрт харьяалахын тийн ялгалын хэдэн зүйл нөхцөлийг тэмдэглэсэн байна.

#### -yīn нөхцөл

А – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Amrayin** γangγayin **oūlayin** qurayin **salayin** talayin  
**Udbalayin** utulγayin **bidayin** jidayin **nilqayin** padmayin  
**Sarayin** tusayin **udqayin** qurmustayin

Е – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Berkeyin** beyeyin **bügüdeyin** ekeyin **kilinčeyin** selteyin  
**Ügeyin** üyileyin **šimeyin** üreyin **čenggelgeyin**

І – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Baqšiyin** γarudiyin **medeqčiyin** nisvaānišiyin **qaršiyin** tarniyin  
**Tobčiyin** sonosuqčiyin **čidaqčiyin** ögöqčiyin **nabčiyin** küjiyin  
**Qumakiyin** tenggeriyin **šaākyamüniyin** asuriyin erketü

О – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Ācoloyin** ċoqcoyin

**U** – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Āinaduyin gluyin uriduyin yartuyin tamuyin**

**Ö** – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Öqligöyin**

**Ü** – эгшигтэй задгай үеэр төгссөн нэр үгийн үндэст залгаж байна.

**Gereltüyin kücütüyin kebelitüyin kürdüyin yertünčüyin**

**Tere metüyin**

**Ay** – дэвсгэр үсгээр төгссөн үгэнд залгаж байна.

**Aljaquy – aljaquyin**

**amuγuūlquy – amuγuūlquyin**

**asaraqy – asaraqyin**

**Bolquy – bolquyin**

**daruquy – daruquyin**

**dalay – dalayin**

**jokilduquy – jokilduquyin**

**oqtorquy – oqtorquyin**

**sonosquy – sonosquyin**

**qarangquy – qarangquyin**

**turangqay – turangqayin**

**delgerenggüy – delgerenggüyin**

**gergey – gergeyin**

**key – keyin**

**kürgeküy – kürgeküyin**

**medeküy – medeküyin**

**nigöülesküy – nigöülesküyin**

**öröšöānggüy – öröšöānggüyin**

**šigidküy – šigidküyin**

**tügeāküy – tügeāküyin**

**jögöy – jögöyin**

**üjeqdeküy – üjeqdeküyin**

**yasutu melekey – yasutu melekeyin**

**ay** – дэвсгэр үсгээр **key, dalay, oqtorquy, qarangquy, melekey** хэмээн тухайн нэр үгийн үндэст төгссөн байхын зэрэгцээ үйл үгийн үндэст – **quy, -küy** дагаврыг залган **kürgeküy, medeküy, šigidküy, sonosquy** гэж хэлбэржүүлсэн үгс түгээмэл байна. **ay** – дэвсгэр үсгээр төгссөн үгэнд – **yin** нөхцөлийг залгахад **ay** – дэвсгэрийг гээж, үгийн үндсийн задгай үед залгаж байна.

**-iyin** нөхцөл

**Am** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд **-iyin** нөхцөлийг залгаж байна.

**Emiyin qaramiyin nomiyin ulamiyin**

**Al** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд **-iyin** нөхцөлийг залгажээ.

**Dusuliyin gereliyin sedkiliyin töröliyin ukaāliyin yaliyin**

**Yabudaliyin köliyin suryaliyin tüsimeliyin üküliyin**

**Ab** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд **-iyin** нөхцөлийг залгасан байна.

**yalabiyin kübiyin tibiysin**

**aq** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд **-iyin** нөхцөлийг залган бичжээ.

**Ayimaq – ayimagiyin**      **čaq – čagiyin**      **mungqaq – mungqagiyin**

**Qamuq – qamugiyin**      **bilic – biligiyin**      **čečeq – čečegiyin**

**Eneckegeq – enedkegiyin**      **erlic – erligiyin**      **Kemkedeq – kemkedegiyin**

**öbödüc – öbödügiiyin**      **jüc – jügiiyin**      **sürüc – süriigiiyin**

Үгийн үндэст нь **ayimaq, jüc, qamuq, enedkeq, öbödüc, čaq, bilic, erlic, mungqaq, čečeq, kemkedeq, süriic** хэмээн дэвсгэрлэх бөгөөд **-iyin** нөхцөлийг залгахад **aq** дэвсгэр үсэг нь **g** үсэг болон хувирч, **-giyin** гэсэн хэлбэрээр бичигдэж байна.

**Ar** дэвсгэр үсгээр төгссөн үгнээ **-iyin** нөхцөлийг залгасан нь

**Dotoriyin yaariyin ijoüriyin niyuüriyin dunduüriyin**

**Öböriyin sangsariyin möriyin üjüüriyin jabsariyin**

**Nököriyin šaliriyin yariyin suduriyin nayijinariyin**

**As** дэвсгэр үсгээр төгссөн үгнээ **-iyin** нөхцөлийг залгасан нь  
**Ecüs – ecüšiyin**                      **toγus – toγušiyin**  
 as дэвсгэр үсэг ecüs, toγus нь **i** эгшгийн өмнө **š** гийгүүлэгч болон хувирч – **šiyin**  
 хэмээн бичигдэж байна.

**Ad** дэвсгэр үсгээр төгссөн үгнээ **-iyin** нөхцөлийг залгасан нь  
**balγadiyin biridiyin nöködiyin balγasun-noγoūdiyin**  
**töbödiyin maqamudiyin**

**-giyin** нөхцөл

**Ang** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд **-giyin** нөхцөлийг залгасан нь  
**amuγuūlanggiyin butunggiyin dunggiyin jobolonggiyin**  
**orçilonggiyin sanggiyin**

**av, ā/ā** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд **-giyin** нөхцөлийг залгасан нь  
**kemjeāgiyin yadoūgiyin**

Өгүүлэхүйд – **ng-** ийн дараа – **g-** өгүүлэгдэх тул **-giyin** хэмээх хувилбар хэлбэрийг залгаж байна. **av, ā/ā** дэвсгэр үсэг нь нэлээд эгшиг шинжтэй тул **-giyin** хувилбар нөхцөлийг залгажээ.

**-i** нөхцөл

Тийн ялгалын **-i** нөхцөлийг залгасан нь

Burqani yabudaliyin oron	keni cikiini ügen-dür	tedeni tenggeri
Ijoürtani köböün	arašaāni usun	nasuni kemjeā
Buyani deādü üre	toāsuni oron	töüni jarligi sonosun
Adoūsuni töröl	bidani beye	qatuni nököd
Nidüni manglay		

Харьяалахын тийн ялгалын **-i** нөхцөлийг **an** дэвсгэр үсгээр төгссөн үгэнд залгасан байна. Тод үсгийн харьяалахын тийн ялгалын үндсэн нөхцөл нь **-yin, -iyin, -i** энэ гурван хэлбэр юм. Эдгээр нөхцөл нь гийгүүлэгчээр эхэлсэн, эгшгээр эхэлсэн учраас **Э+ yin, Г+ iyin, Г+i** хэмээн үгийн үндэст залгаж байгаа нь монгол хэлэнд үгийн бүтцэд дараалсан хоёр буюу хэд хэдэн эгшиг, эсвэл хоёр буюу хэд хэдэн гийгүүлэгч өгүүлэгддэггүй тул эгшиг + гийгүүлэгч, гийгүүлэгч + эгшиг зохицлоор бичих ёсыг гол болгожээ. Задгай үе + **yin**, битүү үе + **iyin**, **n + i** хэмээн залган бичих нь тод үсгийн харьяалахын тийн ялгалын зөв бичихүйн үндэс болно. Үүний зэрэгцээ **-giyin** гэсэн хувилбар нөхцөл бичгийн хэлэнд буй болсон. Үүнийг өгүүлэхүйн учир шалтгаанаар – **ng, – av, – ā/ā** дэвсгэр үсгээр төгссөн үгнээ залган бичиж байна. Тод үсэгт тухайн үеийн аман хэлнийхээ өгүүлэхүйн онцлогийг сайтар тусгасны баримт нь энэ буюу. Ер тод үсгийг найруулсан нэгэн зүйл зорилго нь ярианы хэлээ дөхүү байдлаар тэмдэглэхэд оршиж байсан бололтой.

### Өгөх оршихын тийн ялгал

Их хөлгөн судрын бичвэрт – **du, – dü, – tu, – tü** нөхцөлийг тухайн тийн ялгалын утга үүргээр түгээмэл бичсэн байна.

**-du, -dü** нөхцөлийг бичсэн байдал нь

• **A, e, i, u, ü, ö, (o)** эгшиг бүхий задгай үеэр төгссөн үгийн үндэст залгажээ.

Beye-dü	bodhi-du	ekedü	metü-dü	inadu cinadu-du
Ölmidü	oūladu	bügüdedü	çimadu	gegeāreqçi-dü
Raqula-du	üye-dü	ürgülji-dü	tala-du	jüq jobki-du
Öqligö-dü	önggödü	qubidu		

• An, ay, am, al, ang, ā/ā дэвсгэр үсгээр төгссөн үгийн үндэст залгажээ.

Amin- <b>du</b>	bayilduquy- <b>du</b>	čaāsun- <b>du</b>	ireqsen- <b>dü</b>	įjoūrtan- <b>du</b>
Amitan- <b>du</b>	daširam- <b>du</b> ču	bükün- <b>dü</b>	įayaātan- <b>du</b>	oqtorıyuy- <b>du</b>
Baroūn- <b>du</b>	įam- <b>du</b>	dürsün- <b>dü</b>	įöüdü- <b>dü</b>	orčilong- <b>du</b>
Bidan- <b>du</b>	įasaqlaquy- <b>du</b>	eden- <b>dü</b>	įüreken- <b>dü</b>	sedkil- <b>dü</b>
Toāsun- <b>du</b>	šireādü	qaān- <b>du</b>	umay- <b>du</b>	yabuquy- <b>du</b>
Unaquy- <b>du</b>	nom- <b>du</b> čü			

-du, -dü нөхцөлийг нэрийн үндэст голдуу дагуулсан байхын зэрэгцээ залгаж бичсэн, бас нэг үгэнд amitan-du, amitandu хэмээн дагуулж, залгаж бичсэн тохиолдол байна.

-tu, -tü нөхцөлийг бичсэн байдал нь

Aq, ar, ab, ad, as, дэвсгэр үсгээр төгссөн үгийн үндэст залгажээ.

Aqlaq- <b>tu</b>	ča- <b>tu</b>	čubaq- <b>tu</b>	debisker- <b>tü</b>	kemkedeq- <b>tü</b>
įajar- <b>tu</b>	įalab- <b>tu</b>	įüq- <b>tü</b>	qamuq- <b>tu</b>	böjįiq-noyoūd- <b>tu</b>
balıad- <b>tu</b>	busud- <b>tu</b>	nököd- <b>tü</b>	niyuūr- <b>tu</b>	įemis- <b>tü</b>
įabsar- <b>tu</b>				

Хөлгөн судрын бичвэрт aģiūna, gerte хэмээн бичсэн байгаа нь монгол бичгийн хэлнээ -a/e нөхцөлийг орших орныг илэрхийлэх утга үүргээр бичдэгийг уламжилжээ гэж үзэж болох боловч аман хэлнээ ийнхүү өгүүлдэгийг тэмдэглэсэн арга нь энэ буюу.

#### Заахын тийн ялгал

-gi нөхцөлийг заахын тийн ялгалд бичсэн нь

amuıuūlang- <b>gi</b>	orčilong- <b>gi</b>	orčiūluqči- <b>gi</b>	qab qarangquy- <b>gi</b>
nidütey- <b>gi</b>	soūquy- <b>gi</b>	üjüūlküy- <b>gi</b> čü	sedkiši ügey- <b>gi</b>
įarquy- <b>gi</b>			

-gi нөхцөлийг -ng, -au дэвсгэр үсгээр төгссөн үндэст, бас -i- эгшгээр төгссөн үгийн үндэст дагуулсан байна.

-i нөхцөлийг бичсэн нь

Eldebi	įüyili	mungqagi	nisvaāniši	üyirme- <b>gi</b>
Nomi	qamugi	įajari	köūkedi	küčiri
Tedeni	amitani	üjüūri	šimnuši	

-i нөхцөлийг ab, al, aq, as, am, ar, ad, an дэвсгэр үсгээр төгссөн үгнээ залгаж бичжээ. Үүнийг холбоо үгийн утгаар тодотговоос

Tedeni sakın üyiledkü amitani oıyoāto bolbosuroūlun

Dayini darun burqan-noyoūdi ilerkey maqtabay

Qamugi maqtaqsan arban qoyor įüyili sayitur üyiledkü

Öböri čü yekede sakın

үгийн хэлбэржилт ийм бөгөөд Tede bügüdey bi namančilamuy. Taraān bügüdey olqu boluyu. хэмээн – e- эгшгийн дараа шууд – i нөхцөлийг залгасан хэлбэр байна.

#### Гарахын тийн ялгал

-eāče нөхцөлийг гарахын тийн ялгалын утгаар бичсэн нь

Dayisun – eāče	ıasalang-eāče	nayıjınar -eāče	orčilong -eāče
Quraqsan -eāče	šiltaān -eāče	toāsun -eāče	botoyo -eāče
Ebečin -eāče	tala -eāče	emün-e -eāče	nüken -eāče
Sedkiküy -eāče	teden -eāče	üyiledküy-eāče	šinjileküy -eāče
Debisker -eāče	gerel -eāče	küliāsün -eāče	

Гарахын тийн ялгалын -eāce нөхцөлийг эр үг, эм үг алинд ч задгай, битүү үеэр төгссөн үгийн үндэст дагуулж байна.

#### Үйлдэхийн тийн ялгал

-yeār нөхцөлийг үйлдэхийн тийн ялгалын утгаар бичсэн нь  
Adisted –yeār qudqqsan-yeār yar-yeār eber-noᠶoūd-yeār  
Qaloūn-yeār šiltaān-yeār ʎal-yeār böāljisün-yeār  
jiryalang-yeār uqaān-yeār jam-yeār бүкүн-yeār  
ukaāl-yeār čikin-yeār tor-yeār ebečin-yeār  
tejeāl-yeār süjüq-yeār ed-yeār mököril-yeār  
kücün-yeār jüyil-yeār gem-yeār ideān-yeār

-yeār нөхцөлийг ad, ar, ang, al, an, am, qa, (ab, as) дэвсгэр үсгээр төгссөн үгийн үндэст дагуулж бичжээ. Зарим тохиолдолд erkeār, jöügeār, keleār, yosoār хэмээн ярианы хэлээр бичсэн байна.

-beār нөхцөлийг үйлдэхийн тийн ялгалын утгаар бичсэн нь  
arʎamji- beār auᠶa- beār bayasquy- beār nilbusu- beār  
orošiquy- beār ʎoū- beār qomsodquy- beār omorqoquy- beār  
toloᠶoy- beār usu- beār utulya- beār undaāsquy- beār  
erdeni- beār beye- beār ölösküy- beār čimege- beār cü  
terigöü- beār ildü- beār üge- beār üye- beār  
külicenggüy- beār

-beār нөхцөлийг ау дэвсгэр үсэг ба задгай үеэр төгссөн үгийн үндэст дагуулжээ. Уг нөхцөл нь -beār хэмээх нэг хэлбэртэй тул эр үг, эм үг алинд ч бичсэн байна.

#### Хамтрахын тийн ялгал

-luᠶaā, -lügeā нөхцөлийг хамтрах, холбох утгаар бичсэн нь  
Amin-luᠶaā amuᠶuūlang- luᠶaā busu – luᠶaā oqtorᠶuy--luᠶaā  
Qaān--luᠶaā šoboūn-luᠶaā šoroᠶ-luᠶaā undaā-luᠶaā  
Biliq-lügeā kücün-lügeā nökör- lügeā

-tay, -tey нөхцөлийг хамтрахын утгаар бичсэн нь  
Amitan-tay amtan-tay tögüsüqsen-tey

Хамтрахын тийн ялгалын утга үүргээр -luᠶaā, -lügeā нөхцөлийг түгээмэл тэмдэглээд, бас -tay, -tey нөхцөлийг бичсэн байна.

#### Нэрийн тооны утгыг тэмдэглэсэн нь

Balašiyin nabči-noᠶoūd daqoūla- noᠶoūdi cü dayisun- noᠶoūdi  
Dürsün- noᠶoūdi dusul- noᠶoūdi erketen- noᠶoūd  
Köūken- noᠶoūdi küji- noᠶoūdi kebeli tü- noᠶoūdiyin  
Modun- noᠶoūd-eāce nom- noᠶoūd qong kereā- noᠶoūd  
Šaravaq- noᠶoūdtu cü sang- noᠶoūdi taraālang- noᠶoūdtu  
Tenggeri- noᠶoūdiyin toāsun- noᠶoūd arban jüq- noᠶoūd-tu  
Tüšimel- noᠶoūd yabuqci- noᠶoūd eber- noᠶoūd-yeār  
balʎasun- noᠶoūdiyin buyan- noᠶoūd böjic- noᠶoūd-tu  
burqad köböūd nököd balʎadiyin nöködtöān nayijinar

Юмс үзэгдлийн тоог илэрхийлэхэд -noᠶoūd дагаварыг түгээмэл тэмдэглээд, -d, -naᠶ дагаврыг харьцангуй цөөн үгнээ бичсэн байна. Нэрийн олны утга илэрхийлсэн дагавар нь үгийн үндэс үүсгэж, тийн ялгалын нөхцөлийг дагуулан, нэрийн айн үгийг хэлбэржүүлж байна.



**Хамаатуулах утгыг тэмдэглэсэн нь**

Beyebeān čikibeān üsübeān nilbusu-beān  
Debel-yeān töröl-yeān nigen-yeān kürüqsen-yeān

Хамаатуулах утгаар -beān, -yeān нөхцөлийг задгай үе, битүү үеэр төгссөн нэр үгийн үндэст дагуулжээ. Үүний зэрэгцээ залгаж бичсэн нь түгээмэл байна.

Хамаатуулах утгат нөхцөл нь тийн ялгалын нөхцөлийн дараа орж өгүүлэгдэх тул нийлмэл хэлбэрийг тэмдэглэсэн нь

Nigen-deān ečigedeān nöködtöān öböröān dotoroān  
yartaān orondoān qatun-daān sumaān

ихэвчлэн тухайн үгийн үндэст залган бичсэн, заримдаа дагуулж бичсэн тэмдэглэгээ байсаар байна.

Эрдэмтэн Х. Лувсанбалдан тод үсгийн судалгааны бүтээлдээ “Тод үсгийн бичиг зохиолоос тийн ялгалын дагаврыг авч үзвэл монгол бичгийн хэлэнд байдаг дагаврыг л ярианы хэлэнд ойртуулж тодорхой болгосон байна” (1975: 47) хэмээн тэмдэглээд, тод үсгийн тийн ялгалын дагаврыг харьяалахын тийн ялгалд -yin, -(gi) yin, -(i)yin, -i; өгөх оршихын тийн ялгалд – du/- dü, – tu/-tü; заахын тийн ялгалд – yi, – i, – gi; гарахын тийн ялгалд – eče; үйлдэхийн тийн ялгалд – bēg, – yēg; хамтрахын тийн ялгалд – tai, – tei, – toi,- töi, үүнээс гадна – luᠢā, – lügē; олон тоо заах – noᠣoud, үүний зэрэгцээ – nar/- ner, – d дагаврыг ховор хэрэглэсэн (1975: 46-52) гэж тодорхойлсон байдаг. Тод үсгийн бичвэрийн хэлний зүйг судалсан зарим судлаач тийн ялгалын нөхцөлийг тодорхойлон тэмдэглэсэн (6), тод үсгийн тийн ялгалын нөхцөлийн байрыг ажиглан тодорхойлсон (Даваадорж, 2017: 105-113) судалгаа бий.

Их хөлгөн судрын бичвэрийн нэрийн тийн ялгалын тэмдэглэгээ нь дурдсан судлаачдын тодорхойлон тэмдэглэсэнтэй тохирч, тод үсгийн тийн ялгалын судалгааг тодотгон баталгаажуулсан хэрэглэгдэхүүн болж байна.

Тод үсгийн бичвэрт нэр үгс нь өгүүлбэрт тийн ялгалаар хувирч хэлбэрждэг. Тийн ялгалын нөхцөлийг нэр үгийн үндэст залгана. Монгол бичгийн хэлэнд үйл үгийн үндэст залгаад нэр үгийн үндэс үүсгэдэг бүлэг дагавар бий. Тухайлбал – quy, – küy, – qsan, – qsen, – qson, – qson, -daᠢ, – deg, – ᠢa, – ge, – qči эдгээр дагаврын араас тийн ялгалын нөхцөл залгаж болдог. Энэ ёсоор тод үсгийн бичвэрийн бичгийн хэлний найруулгад

Adistidleqsen-yeār, aldaršiqsan-du, amuyūlquyin, ayiladqaqsan-du, badaraqsani, bayasquy-beār, bayasulčaqsan- yeār, bayilduquy-du, boluqsani, boluqsan- yeār, boluqsan-du, dabqurlaqsan-du, doūrisqaqsan-du, düürüqseni, edegeāküyin, edleqseni, ilayuqsani, namančilaqsan- yeār, namančilaqu-yin, nöqčiqsön- yeār, odquy-du, odquyin, ögöqčiyin, ölösküy-beār, omorqoquy-beār, örgöjīqsöni, ötölküyin, qomsodquy-beār, tögüsüqsen-tey, tögüsüqsen-yeār, tusalaquy-du, tusalaquyin, uduriduqči-yi, üjeqdeküyin, üjüülüqseni, unaquy-du, unaquyin, undaāsuqsani, ungšiqsani, untaqsan-du, üyiledüqsen-yeār, üyiledüqseni, yabuquy-du,

ийм хэлбэржилт түгээмэл байна. Энэ нь бичгийн хэлний найруулгын нэгэн зүйл онцлог болно.

Монгол хэлний өгүүлэхүйн онцлогийг хэрхэн тусгасныг бид монгол бичгээсээ харж болдог. Бичгийн хэлний энэ онцлогийг монгол бичигт суурилан найруулсан тод үсэгт уламжилсан байдаг. Үүнийг хэрхэн уламжилсан, ямар онцлог байгааг их хөлгөн судрын бичвэрээс тодруулан үзье. Бичгийн хэлний холбох тогтолцоонд тухайн үгийн үндэс нь ямар үсэг, үеэр төгссөнийг чухалчилна.



Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **а** эгшигтэй задгай үеэр төгссөн нь

Alda	aliqa	amta	aqa	arҗa	ašida
aya	ayungҗa	bataҗana	baqa	basa	bimba
bumba	byeва	čalma	dunda	җula	daruyida
җalbingҗa	җida	maqa	niҗuča	nilqa	nada
naya	niqta	oūla	čuqula	padma	sala
Sara	saba	šara	qurča	tula	tulada
tusa	qarčaҗa	qurmusta	tala	quluҗuna	qura
Raқula	ubasanҗa	udqa	urida	daqoūla	yaқša
Udpala-udbala					

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **е** эгшигтэй задгай үеэр төгссөн нь

Belge	berke	beye	čenggelge	deāre	deārme
Dergede	ečige	eke	ene	ere eme	emüne-ümüne
Erke	ese	kürülge	kerbe	kilinče	mese
Meke	nerе	nūke	nemürge	öüde	šime
Selte	šine	sürčilge	tende	tere	üge
Üre	ürgilҗide	üye	üyile	yeke	yekede

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **и** эгшигтэй задгай үеэр төгссөн нь

Adali	ali	ariki	asuri	arҗamҗi	baқši
Bi	bičičāči	bodaҗali	boҗoni	būri čü	čeāҗi
Činaқši	čini	deāreki	ebčöübči	egeči	erdeni
Eši	inaқši	җüq җübki	küҗi	kebeli	kebteši
Maši	mini	nabči	nilči	nayіҗi	ölmi
Otoči	qarši	qubi	söni	soūri	tüleši
Turši	tusbūri	tarni	ubaši	üҗemҗi	ürgülҗi
Yelbi					

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **о** эгшигтэй задгай үеэр төгссөн нь

Bodo	čoқčo	qolo	boqdo	dotoro	qoyino
Čino	ončo	qoyišida	čolo	ongyočo	yoso
oҗoāto					

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **u** эгшигтэй задгай үеэр төгссөн нь

Aqu	busu	buyu	batu	časutu	činartu
Čoqtu	damaru	dorodu	җartu	glu	inadu
Nasutu	noyirtu	očirtu	qutuqtu	qamtu	qayibu
Qayiratu	qoāru	qorotu	qotu	qoyitu	šatu
Sumu	šuru	tabaqtu	tamu	urtu	uridu
Yanҗu	yasutu				

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **ö** эгшигтэй задгай үеэр төгссөн нь

Bögöāsü	ken čü	deādü	mörtü	töröltü	yertüncü egešiqtü
erketü	gereltü	ildü	nidütü	törölkitü	

jemistü kücütü küliäsü kürdü kebelitü ügetü  
Ülü

Монгол бичгийн хэлнээ нэрийн айн үгийн үндэс нь а,е,и,у,ü эгшигтэй задгай үеэр төгссөн байдаг. Тод үсгийн бичвэрт нэрийн айн үгийн үндэс нь а,е,и,о,у,о,ö,ü эгшигтэй задгай үеэр төгсөж байна. Тод үсгээр тэмдэглэж байх үед үгийн тэргүүн үеэс хойш о,ö эгшиг өгүүллэгддэг байжээ гэж үзээд яг баримтлан тэмдэглэжээ хэмээвээс зохих мэт боловч Ойрад аялгуунаа урт ē, ī, ō, ō авиаг үл өгүүлэн (Лувсанбалдан, 1975: 141-146), ā, ā авиаг тод өгүүлж байгааг тод үсэгт “удаан” хэмээх тэмдгээр тэмдэглэсэн нь авианы өгүүлэхүйн онцлогт тохирсон (Даваадорж, 2015: 141-146), байхын зэрэгцээ Ойрад аялгуунаа үгийн тэргүүн үеэс хойш о, ö уруулын авиа үл өгүүлэгддэгийг илэрхийлж байж болохоор байна. Бичгийн хэлэнд ярианы хэлний өгүүлэх байдлыг яг баримтлан тусгах боломж бага. Ярианы хэлнээ эр, эм эгшгүүд нэгэн үгийн дотоодод холилдон үл өгүүлэгдэх тул энэ онцлогийг тод үсгийн тэмдэглэгэнд харгалзаж, үгийн тэргүүн үед о эгшиг байваас тэргүүн бус үеүдэд о эгшигтэй, үгийн тэргүүн үед ö эгшиг байхулаа тэргүүн бус үеүдэд ö эгшигтэй хэмээн эр, эм эгшгийн зохицлыг харгалзсан бололтой.

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **an** дэвсгэр үсгээр төгссөн нь

Aduūsun – adoūsun	altan	aman	amitan	arašaān
arsalan – arslan	buyan	arban	ariūn	burqan
Amtan – amta	botoyon	badqan	balyasun	böäljīsün
Kelen – kele	baroūn	bayan	biraman	bayilduyaān
Doūn – doū	bükün	büliān	čayaān	buryasun
Ebečin – ebeči	časun	čöān	čösün	čusun
Erten – erte	čuūlyan	čineān	čaāsun	doloān
ĵayaān – ĵayaā	dörbön	dayisun	dayin	eĵen
naādun ineādün	eriken	erketen	esürün	ĵučin
nilbusun – nilbusu	gegeān	gün	göroāsün	ilayun
öbösun – öbüsun	imaqtan	inggen	ĵjoūrtan	ĵaān
örgön – örgün	ĵayasun	ĵiran	ĵöälön	ĵarimdaān
kümün – kümü	ĵoūn	ĵöūn	ĵuĵaān	ĵulĵayan
küūken – köūken – köūke	ĵun	ĵuryaān	ĵandan	ĵayaātan
küčün – küčü	naran	narin	nidün	nayiman
nasun – nasu	noyon	ödkön	nüčügün	ölöqčün
nigen – nige	sadun	köyitön	küleāsün	köböūn
okin – oki	ken	köšöūn	maqan	mergen
olan- olon – olo	modun	mingyan	mönggön	müren
šüteān – šütüān	mün	odqon	orčün	oron
šüūsün-šüūsü	oyoūn	qurdun	qatun	qodaldučin
sanaān-sanaā	qaloūn	qaān	qoāson	qorumqan
šoboūn-šubuūn	qošoūn	sayin	šeāsün	sanĵilyan
toāsun-toāsu-toāson	sarbečin	seriūn	šiltaān	šürbūsün
ündüsün-ündüsü	šürüūn	toyin	tümen	türgen
usun-usu	tabun	tabin	taraān	temeān
yasun-yasu	teyin	toārin	terigöūn	terigöūten
yosun-yoso	toryon	ulaān	üčüūken	tögünčilen

yoūn-yoū	undaān	ünen	ünegen	ünen
šara šoboūn	uran	urin	utaān	uqaān
šara üsün	yesün	yoboūn	zandan	yambarçilan

Тод үсгийн бичвэрт зарим үгийг – n – тэй, – n үгүй хоёр хэлбэрээр тэмдэглэсэн нь бий.

Amtan – amta	kelen – kele	nilbusun – nilbusu
Doūn – doū	ebeçin – ebeçi	ĵayaān – ĵayaā
erten – erte	nasun – nasu	yosun – yoso
Yoūn – yoū	kümün – kümü	köūken – köūke
Küçün – küçü	okin – oki	olon – olo
Toāsun – toāsu	ündüsün – ündüsü	usun – usu
Yasun – yasu		

Иймэрхүү бичлэг Их хөлгөн судрын бичвэр дотор байна. Үүнийг тодотговоос Gešüüni erketü бүкүн-yeār **gešüü** çimen, inadu çinadu-du **oro** ebden ülü üyiledün, oyoāto tedkükü qor ügey bolyon **dayisu** ügey bolyoqu, qaldaqu **ebeçi** ügey bolyon, arban jüq-tü **oroçü** sakın üyiledkü.

Эдгээр үгсийг заахын тийн ялгалын утгаар хэлбэржүүлэхэд үгийн эцсийн – n -ийг гээж хэлбэржүүлсэн байна. Энэ нь аман хэлэндээ ийнхүү өгүүлснийг бичигт тэмдэглэж байна. Ийм үзэгдэл эдүгээ ойрад аялгуунаа байгаа билээ.

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **am** дэвсгэр үсгээр төгссөн нь Daširam em ĵam ĵarim nom qaram tulum ulam

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **al** дэвсгэр үсгээр төгссөн нь

Ayoūl	bürküül	damnal	debel	maqtaāl	mederel
Mököril	tüsimel	toqtoāl	urul	yabudal	durašil
Dusul	erel	nayiljoūr	yal	neāmel	tötöl
Töröl	urusqal	gerel	ibeāl	iröāl	itegel
jüyil	osoldol	suryal	tejeāl	übül	udal ügey
jokoāl	küsel	keröül	köl	könöāl	sanal
sedkil	tügeāmel	takil	ukaāl	ükül	

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **ang** дэвсгэр үсгээр төгссөн нь

amuyūūlang	bayasqulang	yasalang	ĵiryalang
jobolong	üjesküleng	gelüng	orçilong
tonting	taraālang	dung	düūreng
kiling			

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **av** дэвсгэр үсгээр төгссөн нь

Buruū	dotoū	döū	doū – doūn	delgüū balyad
yaljoū	yadoū	yoū	yoū – yoūn	terigöū
gešöū	iroū	qatoū	küjüū	moū
oū				

-av дэвсгэр үсэг ойрад аялгуунаа ū/ü урт эгшгийг тэмдэглэж байна. -av дэвсгэр үсэг хэмээх нь байраараа эгшгийн дараа орох учир бичгийн хэлний эртний уламжлал, тогтолцоо ёсоор -av дэвсгэр үсэг хэмээн нэрлэжээ. -av дэвсгэр үсэг нь “Үсгийн найрлага оршив” хэмээх гар бичмэлд (Үсгийн найрлага: 3) тэмдэглэснээр тод үсгийн арван гурван дэвсгэр үсгийн нэг болно. Тод үсэг судлаач Г. Жамьян “Тод үсэг” бүтээлдээ арван гурван дан дэвсгэр үсэг, гучин давхар дэвсгэр үсэг (1991: 15) хэмээн тодруулан тэмдэглэсэн байдаг.

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **ay** дэвсгэр үсгээр төгссөн нь

amurlingyui	beyetey	činaduy	činartay	čölörköy
ayoül ügey	aγuy	aquy	ayoültay	badarangγuy
bayasultay	čirayitay	balay	buy	dabalγatay
damnaqu ügey	dalay	dam ügey	duratay	dayisu ügey
degerengγüy	doütay	eämneltey	ebečitey	ebeči ügey
eserüntey	kir ügey	manglay	mangnay	γayiqamšiqtay
moγoy	muqulay	oyoütay	qatuqtay	osoldol ügey
oy šuyuy	qoāloy	qoroqoy	ünürtey	qočorli ügey
tačaāngγuy-tačiāngγuy		üyetey	juruq-tay	tačiāqu ügey
ireā ödüy	düley	gemtey	jemistey	jokis ügey
jokistoy	jögöy	nelüngkey	nigetey	niγuūr-tay
nilbusu-tay	nöködtöy	nomtoy	noqoy	qab qarangquy
qaram ügey	qoūray	qarangγuy	qubitay	šürbüsün ügey
toā ügey	šüdütey	toāsu ügey	todorqoy	üyiledkü ügey
yabuquy odon	toloyoy	γoriqu ügey	key	yasutu melekey
yadoūraqu ügey	küličengγüy	ketürkey	köndöy	kijaār ügey
kičiāngγüy	nidütey	oqtorγuy	öljöy	öröšöāngγüy
öqligötöy	önggötöy	onomoqoy	toūlay	taālamji ügey
taālamjitay	turangqay	toloyoy	tor ügey	üjeskülengtey
üjemji ügey	udal ügey	ulustay	toā ügey	

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **aā/eā** дэвсгэр үсгээр төгссөн нь

Deāme-lügeā	erikeā	kereā	kejeā	ideā-ideān
Sanaā-sanaān	kemjeā	kököā	ödügeā	qamiyaā
Qoroā	šüteā	šireā	toā	

Эгшгийн дараа байрлаж байгаа учраас **-ā/-ā** дэвсгэр үсэг хэмээх бөгөөд бичвэрт, судалгааны түвшинд “удаан” хэмээх тэмдэглэгээ гэдэг. Энэ нь тод үсгийн арван гурван дэвсгэр үсгийн нэг юм.

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **-ab** дэвсгэр үсгээр төгссөн нь

Cambutib-zambutib	eldeb	γalab	küb	köb	tib
-------------------	-------	-------	-----	-----	-----

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **-aq** дэвсгэр үсгээр төгссөн нь

Aqlaq	bilīq	bölöq	böjiq	bulaq
Čaq	čečeq	čimeq	čoq	čubaq
Čerīq	adaq	amaraq	enedkeq	erliq
Irmeq	jarliq	jasaq	jemseq	jüq
jüq jübki	juruq	ayimaq	kemkedeq	mungqaq
öbüdüq-öbödüq	önišiq	ončaliq	qutuq	qamuq
qonoq	qoūrmaq	sürüq	süjüq	tungγalaq
šarabaq-šravaq	üjüq	üyirmeq	tangsuq	toārčoq

Монгол бичигт **-aγ**, **-eg** хэмээн эр, эм үгнээ бичдэг дэвсгэр үсэг бий. Энэ нь үгийн адагт дуугүйшдэг авиаг тэмдэглэдэг. Эл онцлогийг тод үсгийн бичвэрт тодорхой болгон **-aq** дэвсгэр үсгээр эр, эм аль ч үгнээ бичдэг. Тухайн авианы үгийн адагт болон дуугүй гийгүүлэгчийн өмнө дуугүйших онцлогийг тусган нэгэн дүрсээр тэмдэглэжээ.

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **-as** дэвсгэр үсгээр төгссөн нь  
 Bars ečüs jemis nisvaānis šumnus  
 тоγус төгүс

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **-ad** дэвсгэр үсгээр төгссөн нь  
 Abquy balγad akaād birid busud ed  
 Köūked kitad maγad maqamud pradi gabud  
 Qošoād subud töböd tegeād niĵeād

Их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс **-ar** дэвсгэр үсгээр төгссөн нь  
 Aldar baātar činar dötögöār dunduūr  
 Debisker eber γadar γaĵar γutayaār  
 γar ger güĵir iĵoūr itegel  
 ĵabsar öbör ödür öndür ötör  
 očir oqor tüyidker töšör todqor čü  
 kükür ĵoāqloūr küčir kiĵaār yesüdügeār  
 kökör qabar qoābur qor qoyor  
 šalir sūr tömür üĵüūr ünür  
 mör muqur nökör noūr nayilĵoūr  
 niγoūr-niγuūr sangsar šastir sayitur sayibeār  
 šidar söüder sudur üliĵer ulabur šara  
 yambar

## ДҮГНЭЛТ

Тод үсэгт арван гурван дэвсгэр үсэг бий. –aš дэвсгэр үсгээр төгссөн үг цөөн. Эдгээр арван гурван дэвсгэр үсгээс их хөлгөн судрын бичвэрт нэрийн айн үгийн үндэс арван хоёр дэвсгэр үсгээр төгссөн байна.

Орчин цагийн утга зохиолын хэлний талаас, эдүгээ үеийн ойрад аялгууны өгүүлэхүйн байдлаас үзвэл, an, am, al, ang, ab, aq, as, ad, ar есөн дэвсгэр үсэг нь хэлний эртний үед ч, эдүгээ үед ч гийгүүлэгчийн үүргээр байсаар байна. Av, ay, ā/ā дэвсгэр үсгүүд нь хэлний авианы хувьсал хөгжлийн явцад эгшиг үсэгт хувирсан. Av, ay, ā/ā дэвсгэр үсэг нь эгшгийн дараа байрлан үе бүтээж, үе хаах тул дэвсгэр үсэг лүгээ адилтган үзсэн. Ийнхүү дэвсгэр үсэг хэмээсэн нь монгол бичиг, тод үсгийн тогтолцоонд зохистой байхын хамт тухайн үеийн монгол хэлний онцлог баримтыг хадгалсаар байгаа билээ. Эдүгээ мянга хэдэн зуун жилийн түүхтэй монгол бичиг, гурван зуун дал гаруй жилийн түүхтэй тод үсгийн ач холбогдол оршоор байна, хойшид ч оршоор байх болно.

## Ашигласан бүтээл, хэрэглэгдэхүүн

Altan Gerel: Die westmongolisch Fassung des Goldglanzsūtra nach einer Handschrift der Kgl. Bibliothek in Kopenhagen (1929). Herausgegeben von Erich Haenisch. Leipzig: Verlag der Asia Major.

Батсуурь, А. (2008). Тод үсгийн судрын тархан ба бичиг үсгийн соёл. Тод үсэг – 360. Олон улсын шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Ховд: Ховд Их сургууль, Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль. 21–30.

- Бичеев, Б. А. (2015). Глава «О пустоте» из Ойратского перевода «Сутры золотого света». Вестник Калмыцкого института гуманитарных исследований РАН. 8. № 3. 155-165. – EDN VDKJMJ.
- Даваадорж, Б. (2017). Тод үсгийн тийн ялгалын талаарх харшуулсан ажиглалт. “*Ойрад монголчуудын биет бус соёлын өв*” ОУЭШ-ний V хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар.
- Даваадорж, Б. (2015). *Хэл аялгуу судлалын зарим асуудлууд*. Улаанбаатар.
- Жамьян, Г. (1991). *Тод үсэг*. Ховд.
- Лувсанбалдан, Х. (1975). Тод үсэг, түүний дурсгалууд. Улаанбаатар.
- Үсгийн найрлага оршив. Гар бичмэл. 4 тал.
- Цэндээ, Ю. (2012). Ойрад аялгууны хэлзүй. Улаанбаатар.
- Qutuqtu suduriyin ayimagiyin erketü qaān deädü Altangerel kemeākü yeke kölgöni sudur orošiboy. Бичмэл. Шифр: 0127.
- Yakhontova, N. (2006). Mongolian and Oirat Translations of the Sutra of Golden Light. Silk road documents: The transmission of the Suvarnaprabhasottamasutra. Symposium under the Ford Foundation. Beijing. 94-98.

## References

- Altan Gerel: The westmongolisch Fassung des Goldglanzsūtra nach einer Handschrift der Kgl. Bibliothek in Copenhagen* (1929). Herausgegeben von Erich Haenisch. Leipzig: Verlag der Asia Major.
- Batsuuri, A. (2008). Tod üsgiin sudryn tarkhan ba bichig üsgiin soyol. *Tod üseg – 360. Olon ulsyn шинжилgeenii бага khurlын илтgeiin emkhtgel*. Khovd: Khovd University, School of Social Sciences and Humanities. 21–30.
- Bichyeyev, B. A. (2015). Glava “O pustotye” iz Oiratskogo pyeryevoda “Sutry zolotogo svyeta” [Chapter “On the emptiness” from the Oyrat translation “Sutras of the Golden World”]. *Bulletin of the Kalmyk Institute for Humanitarian Studies of the Russian Academy of Sciences*. 8. № 3. 155-165. EDN VDKJMJ (in Russian).
- Davaadorj, B. (2017). Tod üsgiin tiin yalgalyн talaarkh kharshuulsan ajiglalt. *Oirad mongolchuudyn biyet bus soyolyn öv* (Proceedings of the 5th IOC Conference on “Intangible Cultural Heritage of the Oirat Mongols”). Ulaanbaatar.
- Davaadorj, B. (2015). *Khel ayalguu судлалын зарим асуудлууд*. Улаанбаатар.
- Jamiyan, G. (1991). *Tod üseg*. Khovd.
- Luvsanbaldan, Kh. (1975). *Tod üseg, түүний дурсгалууд*. Улаанбаатар.
- Üsgiin найрлага оршив. Гар бичмэл. 4 тал.
- Tsendee, Yu. (2012). *Oirad ayalguuny khelzүй*. Улаанбаатар.
- Qutuqtu suduriyin ayimagiyin erketü qaān deädü Altangerel kemeākü yeke kölgöni sudur orošiboy. Bichmel. Shifr: 0127.